



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



UN
DP

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫГ САЙЖРУУЛАХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУРААНГУЙ ҮР ДҮН

2024 ОН

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын хэмжээнд нийт 254.9 мянган аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй ч тэдгээрийн дөнгөж 35-39 хувь нь л үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулж буй нэг аж ахуйн нэгжид дундажаар 5 цалинтай ажиллагч ногдож байгаа нь хувийн хэвшлийн чадамжийг тодорхойлж байна. Ялангуяа бүртгэлтэй ААН-үүдийн тал хувь нь үйл ажиллагаагаа түр эсвэл бүрэн зогсоосон хэлбэртэй байгаа нь Монголд бизнес эрхлэх амаргүй, тогтвортой үйл ажиллагаа явуулахад маш хүндрэлтэй болохыг харуулж байна.

2021 онд Монгол банкнаас хийсэн Монгол улсын бизнес орчны үнэлгээгээр бизнесийн ерөнхий орчин муу байгаа гэсэн үр дүн гарсан. Энэхүү нөхцөл байдалд нөлөө үзүүлж буй томоохон хүчин зүйлийн нэг бол санхүүжилтийн орчин муу байгаа явдал юм. Хэдийгээр Монгол Улсын Засгийн газар тусгай сангуудаараа дамжуулан жил бүр 70-130 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, тэтгэлэгийг бизнес эрхлэлтийг дэмжих, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгодог боловч эдийн засгийн өсөлт, төрөлжилт, ажлын байрны тоонд өөрчлөлт ороогүй, ядуурал хэвээрээ байсаар байна. Өөрөөр хэлвэл, дан ганц санхүүгийн дэмжлэг олгосноор санхүүжилтийн орчин сайжрахгүй, татварын болон бусад зохицуулалтыг бизнест ээлтэй болгож, чанартай хүний нөөц бэлтгэн, зах зээлд шаардлагатай элементүүдийг бүрдүүлсэн цогц арга хэмжээгээр үр дүнд хүрэхээр харагдаж байна.


Улмаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гаас санхүүгийн дэмжлэг олгох бодлого, эрх зүйн орчин, сонгон шалгаруулалтын үйл явц, оролцогч талыг судалсны үндсэн дээр энэхүү үйл явцыг илүү энгийн, ойлгомжтой болгож хөнгөвчлөх загвар боловсруулах, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хэрэгцээтэй санхүүгийн бус үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДҮР ТӨРХ

МОНГОЛД ХӨДӨЛМӨРИЙН НӨӨЦИЙН* АШИГЛАЛТ МУУ БАЙНА.

2013 оноос хойшхи 10 жилийн хугацаанд хөдөлмөрийн насны хүн амын тоо 200 мянгаар өссөн боловч ажил эрхэлдэг хүний тоо өсөөгүй буюу Монгол Улсад хөдөлмөрийн нөөцийн ашиглалт муу байна. 2025 оноос хөдөлмөрийн насны хүн ам өсөх хандлагатай байгаа нь хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлээгүй нөхцөлд ажилгүйдэл, ядуурлыг улам нэмэгдүүлэх буюу нийгэм-эдийн засгийн сөрөг үзэгдлүүд гаарахаар байна.



МУ-д 881 МЯНГАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ АШИГЛАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА, ЭНЭ НЬ 881 МЯНГАН ХҮН АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУР ОРШИЖ БАЙГААГ ХАРУУЛЖ БАЙНА.


Эх сурвалж: ҮСХ-ны мета өгөгдлийн сан 1212.mn

* Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүн ам болон тухайн үед ажиллаж байгаа хөдөлмөрийн бус насны хүн амыг нийтэд нь хөдөлмөрийн нөөц гэнэ

ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын динамик, шалтгааныг харвал байх ёстой тооноосоо илүү байна. Өөрөөр хэлбэл, ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн амын тооны нийлбэр нь хөдөлмөрийн насны хүн амын тооноос илүү гарч байна. Тухайлбал, 2022 оны хувьд хөдөлмөрийн насны 2.06 сая байх боломжтой байгаа ч ажил эрхлэж буй 1180.5 мянга, ажил идэвхтэй хайж байгаа 84.7 мянга дээр (i) тэтгэврийн 372 мянга, (ii) суралдцаг 242 мянга, (iii) хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй 115 мянга, (iv) гэртээ хүүхдээ хардаг 114 мянга, (v) цэрэгт, гадаадад г.м бусад шалтгаантай 215 мянган ажиллах боломжгүй хүнийг нэмэхэд байх ёстой тооноос 228 мянгаар илүү байна.

Энэхүү давхцал 2010-2022 оны хооронд 50-350 мянгатай байсан бөгөөд тэтгэврийнхэн ажил эрхлэх, бусад шалтгаантай хүмүүс ажил хайж байгаа зэргээс үүсч болно. Одоогийн мэдээлэл цуглуулж буй аргачлал нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ажиллах хүчний судалгааны аргазүйн дагуу хийж байгаа ба уг албан ёсны мэдээллийг захиргааны чанартай мэдээллээр нарийвчлах шаардлагатай байдаг хэдий ч манай өнөөгийн Хөдөлмөрийн зах зээл (ХЗЗ)-ийн захиргааны мэдээлэл чанар муу тул эдгээр мэдээллүүдэд давхардал, зөрүү байсаар байна. Үүнээс үүдэн бодлогын томоохон шийдвэр гаргахад хүндрэл, бэрхшээл байсаар байна. Иймд хөдөлмөрийн статистикийг сайжруулах, логик уялдаатай болгох шаардлагатай байна.




Эх сурвалж: ҮСХ-ны мета өгөгдлийн сан 1212.mn

ТЭТГЭВЭРТ ГАРСАН ХҮН АМЫН ТОО НЭМЭГДЭЖ БАЙНА

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тооноос харахад 10 хүний 5 нь ямар нэг шалтгаанаар ажиллах боломжгүй байна.

Тухайлбал, 2 нь тэтгэвэрт гарсан, 1 нь суралцаж байгаа бол өөр 1 нь цомхотголд орсон, байгууллага татан буугдсан, цэрэгт явсан, гадаадад байгаа г.м шалтгаанаар ажил хайх сонирхолгүй байна. Судалгаанаас харахад 2014 онд төрөлтийн тоо 84 мянга байхад 86 мянган хүн гэртээ хүүхдээ хараад ажиллах боломжгүй байсан бол 2022 онд төрөлт 69 мянга болж буурсан ч гэртээ хүүхдээ харагчдын тоо 114 мянга болж өссөн байгаа нь ямар хүчин зүйлээс үүдэлтэйг нарийвчлан судлах шаардлагатай байна.



Эх сурвалж: ҮСХ-ны мета өгөгдлийн сан 1212.mn

ХУВИЙН ХЭВШИЛД АЖИЛЛАГСДЫН ТОО БУУРЧ БАЙНА

Хэдийгээр ажил хийж буй 5 хүний 4 нь хувийн хэвшилд ажиллаж байгаа ч сүүлийн 5 жилийн чиг хандлагыг харахад тоо нь буурч байна. 2019-2022 оны хооронд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо 155 мянгаар, хувийн хэвшилд цалинтай ажиллагсдын тоо 38 мянгаар буурсан нь анхаарал татах асуудал юм. Харин энэ хугацаанд төрийн албан хаагчдын тоо 26.7 мянгаар өсчээ. Өөрөөр хэлвэл, Монголд төрийн алба л шинэ ажлын байр бий болгож буй дүр зураг ажиглагдлаа.




* Хувиараа хөдөлмөр эрхлэгч, мал аж ахуй эрхлэгч, өрхийн үйлдвэр үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, ажил олгогч, бусад цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэгчид

Эх сурвалж: ҮСХ-ны мета өгөгдлийн сан 1212.mn

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД ЭЗЛЭХ ХУВЬ БАГА БАЙНА.


Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын 97.1 хувийг 50 хүртэлх ажилтантай жижиг, дунд бизнес эрхлэгчид эзлэж байгаа бөгөөд тэд хувийн хэвшлийн гол ажил олгогчид юм. Монголын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн жилийн борлуулалтын хэмжээ бүс нутгийн дунджаас 5-6 дахин, Дэлхийн дунджаас 10 дахин бага байгаа шалтгааныг тодруулан судлах шаардлагатай. Шалтгаан нь бүтээмж бага эсвэл албан бус салбарт үйл ажиллагаа явуулж байж болох юм.

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, ажиллагсдын тоогоор




Эх сурвалж: ҮСХ-ны мета өгөгдлийн сан 1212.mn

ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь, 2017 оны байдлаар



Эх сурвалж: Эдийн засгийн хөгжилд ЖДҮ-ийн оруулж буй хувь нэмэр, ҮСХ, 2021 болон сонгосон улсуудын 2017 оны албан ёсны статистик

ТӨРӨӨС СҮҮЛИЙН 10 ЖИЛД 989 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХЭД ЗАРЦУУЛСАН БАЙНА.



Эх сурвалж: Нийтийн нээлттэй мэдээллийн сан shilen.gov.mn

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ИРГЭДЭД ҮЗҮҮЛСЭН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ТУХАЙ

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИДЭВХТЭЙ БОДЛОГО АЛДАГДСАН БАЙНА.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) гишүүн орнуудын дундажтай харьцуулан үзэхэд, манай улсад ХЭДС-аас бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр зарцуулж буй зардал даруй 3 дахин өндөр буюу 59 хувь байгаа ч тавьж буй шаардлагууд нь хувиараа хөдөлмөр эрхлэлтийг урамшуулж, цаашлаад албан бус хөдөлмөр эрхлэлтийг дам байдлаар дэмжиж байна. Түүнчлэн цалинтай хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлогын идэвхтэй арга хэрэгсэл болох ажлын байрны дэмжлэг, хөдөлмөр эрхлэх сонирхлыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй иргэдэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр зарцуулж буй санхүүжилт ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын дунджаас 2 дахин доогуур байв. Энэ нь Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого үндсэндээ алдагдсан гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

БОДЛОГЫН БҮТЭЦ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд зарцуулсан дүнг хувиарлан гаргасан мэдээлэл



ХЭДУА-ны 50 арга хэмжээг 6 бүлэгт хувиарласан дүн /төгрөгөөр/

Ажил хийхэд туслах	Сургалт, ур чадварыг нэмэгдүүлэх	Хөдөлмөрлөх сонирхлыг нэмэгдүүлэх	Хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй хүмүүсийг дэмжих	Ажлын байрыг шууд дэмжих	Бусад (Бизнес эрхлэхэд тусламж үзүүлэх)
756,500,000	771,531,637	1,168,809,500	11,990,341,997	7,260,889,001	31,192,726,129

2023 оны гүйцэтгэлийн мэдээ, ХХҮЕГ-ын 2024.01.11-ны нэгтгэл, excel мэдээ

ИДЭВХТЭЙ БОДЛОГЫН БҮТЭЦ

OECD-ын орнуудын дундаж




Australia (joined 06.1971)	Greece	New Zealand (05.1973)
Austria	Hungary (05.1996)	Norway
Belgium	Iceland	Poland (11.1996)
Canada	Ireland	Portugal
Chile (05.2010)	Israel (09.2010)	Slovak Republic (12.2000)
Colombia (04.2020)	Italy	Slovenia (08.2010)
Costa Rica (May 2021)	Japan (04.1969)	Spain
Czech Republic (06.1971)	Korea (12.1996)	Sweden
Denmark	Latvia (09.2016)	Switzerland
Estonia (12.2010)	Lithuania (08.2018)	Turkey
Finland (01.1969)	Luxembourg	United Kingdom
France	Mexico (05.1994)	United States
Germany	Netherlands	

OECD гишүүн 37 улс /Дэлхийн ДНБ-ий 62.2%/

Улмаар бизнес эрхлэхэд чиглэсэн дэмжлэгт сангийн хөрөнгийн ихэнх хувийг зарцуулж байгаа боловч бизнесийг амжилттай болгоход шаардлагатай санхүүгийн бус дэмжлэг болох сургах, чиглүүлэх, зөвлөх, зах зээлд бараа, үйлчилгээгээ гаргахад дэмжих арга хэмжээнд маш бага хөрөнгийг хуваарилж байгаа нь дээрх сангийн ихэнх хөрөнгийг зарцуулж буй бизнесийг дэмжих арга хэмжээ үр дүнгүй болоход нөлөөлж улмаар санхүүгийн эргэн төлөлтийн хувь эрсдэлтэй түвшинд хүрсэн байна.

ХЭДС-ИЙН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮР ДҮНГҮЙ БАЙГААГИЙН ГОЛ ШАЛТГААН НЬ ЗОРИЛТОТ БҮЛГИЙНХЭЭ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛДОГҮЙ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БУРУУ БАЙГААТАЙ ХОЛБООТОЙ БАЙНА.

ХЭДС-аас иргэнд Санхүүгийн дэмжлэг олгож буй одоогийн процесст дараах асуудал байна. Үүнд:



1. Зорилтот бүлгийг нарийвчилж тодорхойлоогүй тул зорилтот бүлгийн тусгай хэрэгцээнд нийцээгүй. Төслийг бизнесийн хөгжлийн үе шатнаас үл хамааран олгож байна. Өөрөөр хэлбэл өмнө нь бизнес эрхлэж байсан эсэхийг үл хайхран, бичсэн төсөлд нь үндэслэн санхүүжилт олгодог. Гэтэл шинэ бизнесийн санхүүжилт нь хамгийн эрсдэлтэй төрөлд тооцогддог.




2. Санхүүгийн дэмжлэгийн төслийг бизнесийн чиглэлээр мэргэшсэн баг үнэлдэггүй, төрийн захиргааны албан хаагчид үнэлж, олгож байгаа нь үнэлгээний явцад алдаа гарах магадлалыг нэмэгдүүлдэг.



3. Санхүүгийн дэмжлэгийн гол шаардлагуудын нэг болох эргэн төлөлтийг зарим жил төлүүлэх, зарим жил төлүүлэхгүй шийдвэрүүд гаргадаг. Мөн ямар нэгэн хүүгүйгээр олгож буй нь аливаа эрсдэлээс хамгаалах боломжгүй байдалд хүргэж байна. Монголын нөхцөлд мэргэжлийн банкируудын үнэлж олгосон зээлийн 5-16 хувь нь хугацаа хоцорч, дампуурч байгаа нөхцөлд төрийн албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсгийн үнэлж олгох эрсдэл үүнээс өндөр байх боломжтой.


ХЭДС-ААС ИРГЭНД ЗЭЭЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ ДАРААХ ДАРААЛЛААР ЯВАГДАЖ БАЙНА.



ЗӨВЛӨМЖ


БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Бизнесүүдийн хувьд макро эдийн засгийн тогтворгүй байдал, татвар, нийгмийн даатгалын зохицуулалтын асуудлаас гадна зах зээлийн судалгаа хийхгүй, зах зээлд хэрхэн амжилттай нэвтрэхээ мэдэхгүй, гүйцэтгэлийг бодитой үнэлэхгүй, хэт олон чиглэлд хөрөнгө оруулах зэрэг асуудлууд тулгамдаж байна. Өөрөөр хэлбэл, бизнес эрхлэгчдэд дан ганц санхүүгийн дэмжлэг бус бизнесээ хэрхэн зөв удирдан зохион байгуулахтай холбоотой чанартай, үр дүнд чиглэсэн, мэргэжлийн талуудын оролцоог бүрэн хангасан санхүүгийн бус дэмжлэг ч шаардлагатай байна.



Эх сурвалж: Монголын Бизнесийн байгууллагын хөгжлийн судалгаа, Удирдлагын академи, 2018

ЗАРИМ УЛСУУДЫН ТУРШЛАГААС ДУРДВАЛ: Төрөөс хувийн хэвшилд үзүүлэх дэмжлэг нь Малайз, Индонези зэрэг эдийн засгийн өндөр өсөлт үзүүлж буй улсуудын нэгэн адил бизнес эрхлэгчдийн гол хэрэгцээнд нийцсэн, бизнесийн онцлогт тохируулан ажилладаг, мэргэжлийн удирдлага бүхий нэг сувгаар дамжих хэрэгтэй байна.



Эх сурвалж: www.smecorp.gov.my/index.php/en/about/2015-12-21-08-49-11/about-sme-corp-malaysia

САНАЛ БОЛГОЖ БУЙ ШИЙДЭЛ

Цаашдаа нэгдсэн удирдлагатай тогтолцоонд шилжих алсын харааг төлөвлөн, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэнийг 1. бизнес эрхлэж байгаа, 2. бизнес эхлэх гэж байгаа гэсэн бүлэгт хуваан үзэж, санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Зорилтот бүлгээ оновчтой тодорхойлж, богино хугацаанд олон ажлын байр бий болгож чадах шинэ бизнесийг дэмжих нь илүү үр дүнтэй.

a Тодорхой хугацаанд бизнес эрхлэсэн туршлагатай, ажлын байр бий болгох боломжтой бизнест шаардлагатай дэмжих үйлчилгээг (санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль г.м төлбөрт үйлчилгээнүүд) хамт олгох

b Шинээр бизнес эрхлэх гэж буй, урам зориг дүүрэн, сайн төсөлтэй Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих. Үүнийг "crowdfunding"-ийн мэргэжлийн платформуудтай хамтран хэрэгжүүлэх


САНХҮҮГИЙН БУС ДЭМЖЛЭГ

ХЭДС дангаараа бус бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран дараах 2 хэлбэрээр хэрэгжүүлэхийг санал болгож байна.


a Ерөнхий мэдлэг олгох хөтөлбөр: Үүнд, маркетинг, санхүү, хууль, хүний нөөцийн удирдлага г.м бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зүй, бодит туршлага хуваалцах уулзалт, сургалт зохион байгуулах

b Өсөлтөд тэмүүлсэн бизнес эрхлэгчдийн Хурдасгуур хөтөлбөр: Богино хугацаанд өсөлт, амжилт гаргах боломжтой бизнес загвартайгаас гадна хүсэл эрмэлзэл дүүрэн бизнес эрхлэгчдийг сонгон авч 6 хүртэлх сарын хугацаатай Хурдасгуур хөтөлбөрөөр дамжуулан чадавхжуулах

Бизнес эрхлэж буй бүлгийн хувьд эрхлэж буй бизнесийнх нь талаар 1 жилээс дээш хугацааны өгөгдөл үүссэн байх учир, уг өгөгдөлд үндэслэн Зээлжих чадварыг нь тодорхойлсны үндсэн дээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжтой юм. Эхний үед загварчлалын найдвартай байдал сул, босго оноог тогтооход хүндрэлтэй тул ирсэн үнэлгээнүүдийг эрэмбэлэх байдлаар ашиглаж болно.



Бизнесээ эхлүүлэхээр төлөвлөж буй бүлгийн хувьд эрсдэлтэй нөхцөл байдалд дасан зохицох, шийдлээ тууштай хэрэгжүүлэх чадварт нь үндэслэн Бизнесийн сургалт, санхүүгийн бус дэмжлэгт хамруулах нь тухайн хүнийг эрсдэлээс хамгаалах зөв арга зам болох юм.



Хувь хүний бизнес эрхлэх үр чадварын үнэлгээг хэрхэн гүйцэтгэж болох мэдээлэл, асуулгыг судалгааны дэлгэрэнгүй тайлангаас харах боломжтой.